

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИНФЛЮЗЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1.1. Энэ хуулийн зорилго нь нийтийн сүлжээнд инфлюзерийн үйл ажиллагаа, зар сурталчилгаа, ивээн тэтгэлэг, бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга, агуулгын ил тод байдал, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шударга өрсөлдөөнийг дэмжих, хүүхэд болон эмзэг бүлгийг хамгаалах харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэдэд чиглэсэн агуулга нийтэлдэг инфлюзер, тэдгээртэй хамтран ажиллагч сурталчилгааны захиалагч, агентлаг, платформын оролцогч, мөн хэрэглэгчтэй холбоотой харилцаанд энэ хууль үйлчилнэ.

2.2. Монгол Улсад бүртгэлгүй гадаад этгээд Монгол Улсын хэрэглэгчдэд чиглэсэн сурталчилгааны агуулга түгээсэн бол энэ хуулийг мөрдөнө.

2.3. Төрийн байгууллагын албан ёсны мэдээллийн суваг, сонгуулийн хуульд тусгайлан зохицуулсан харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

3 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “инфлюзер” гэж олон нийтэд нөлөөлөх зорилго бүхий контент тогтмол нийтэлж, үзэгч/дагагчтай харилцан үйлчлэл бий болгосон бөгөөд тухайн үйл ажиллагаагаараа шууд/шууд бус орлого олдог хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.2. “арилжааны агуулга” гэж бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэнд, арга хэмжээ, байгууллага, хувь хүн, үзэл санааг дэмжих зорилготой бөгөөд нөхөн төлбөртэй эсхүл үнэ цэн бүхий аливаа ашиг хүртэх нөхцөлтэй контентыг;

3.1.3. “нөхөн төлбөр” гэж мөнгөн төлбөрөөс гадна бэлэг, хөнгөлөлт, аялал, үйлчилгээ, бартер, хувь, урамшуулал, шимтгэл, захиалгат холбоосын орлого зэрэг үнэ цэн бүхий аливаа өгөөжийг;

3.1.4. “ивээн тэтгэлэг” гэж контент бүтээх, түгээхтэй холбоотой зардлыг даах, нэр/лого байрлуулах, үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон санхүүжилт, өгөөжийг;

3.1.5. “платформ” гэж сошиал сүлжээ, видео/подкаст, стрийминг (контент видео, аудио, тоглоом гэх мэт интернэтээр шууд дамжуулан үзэх, сонсох технологи), блог, контент түгээх цахим үйлчилгээ үзүүлэгчийг;

3.1.6. “зорилтот сурталчилгаа” гэж хэрэглэгчийн өгөгдөл, зан төлөв, сонирхол, байршил зэрэгт тулгуурлан чиглүүлсэн сурталчилгааг;

3.1.7. “хүүхэд” гэж 18 нас хүрээгүй иргэнийг;

3.1.8. “эмзэг бүлэг” гэж хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, санхүүгийн болон эрүүл мэндийн эрсдэл өндөр бүлгийг;

3.1.9. “худал (false) төөрөгдүүлсэн (misleading) мэдээлэл” гэж бодит байдалд нийцэхгүй, эсхүл хэрэглэгчийг буруу шийдвэр гаргахад хүргэх агуулгыг;

3.1.10. “харанхуй загвар (dark pattern)” гэж хэрэглэгчийг төөрөгдүүлэх, албадан зөвшөөрүүлэх, далд зардал үүсгэх дизайн/аргыг;

3.1.11. “агентлаг” гэж инфлюенсерийн менежмент, зуучлал, сурталчилгааны үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэгч этгээдийг;

3.1.12. “сурталчилгааны захиалагч” гэж бүтээгдэхүүн, үйлчилгээний сурталчилгааг инфлюенсерээр дамжуулан хийлгэхээр тохирсон этгээд;

3.1.13. Affiliate холбоос (affiliate link) гэдэг нь онлайн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ сурталчилж, тухайн холбоосоор дамжин борлуулалт хийгдвэл шимтгэл (commission) авдаг тусгай линк юм.

4 дүгээр зүйл. Баримтлах зарчим

4.1. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

4.1.1. ил тод, үнэн зөв байх;

4.1.2. хэрэглэгчийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих;

4.1.3. хүүхэд, эмзэг бүлгийг онцгойлон хамгаалах;

4.1.4. шударга өрсөлдөөн, шударга худалдааг дэмжих;

4.1.5. өгөгдөл хамгаалал, хувийн нууцыг хүндэтгэх;

4.1.6. зохицуулалт, эрсдэлд суурилсан хяналт хэрэгжүүлэх.

5 дугаар зүйл. Хуулийн хэрэгжилтийн чиг үүрэг бүхий байгууллага

5.1. Засгийн газар энэ хуулийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг тогтооно.

- 5.2. Эрх бүхий байгууллага нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 5.2.1. бүртгэл, тайлагналын журам батлах, хөтлөх;
 - 5.2.2. ил тод байдлын стандарт, зөвлөмж гаргах;
 - 5.2.3. гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах;
 - 5.2.4. зөрчил шалган шийдвэрлэх, арга хэмжээ авах;
 - 5.2.5. платформ, агентлаг, захиалагчтай хамтарсан зохицуулалт хэрэгжүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ИНФЛЮЗЕРИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, БҮРТГЭЛ

6 дугаар зүйл. Инфлюзерийн ангилал

- 6.1. Инфлюзерийг дараах байдлаар ангилна:
 - 6.1.1. мэргэжлийн инфлюзер;
 - 6.1.2. давхар ажил эрхлэгч инфлюзер;
 - 6.1.3. байгууллагын инфлюзер (хуулийн этгээд);

6.2. Ангиллын шалгуурыг дагагчийн тоо бус, орлогын шинж, арилжааны агуулгын давтамж, захиалгат хамтын ажиллагааны хэмжээг харгалзан эрх бүхий байгууллага тогтооно.

7 дугаар зүйл. Инфлюзерийн бүртгэл

- 7.1. Дараах нөхцөлийг хангасан этгээд инфлюзерийн бүртгэлд бүртгүүлнэ:
 - 7.1.1. арилжааны агуулга нийтлэх замаар тогтмол орлого олдог;
 - 7.1.2. нэг жилд арилжааны хамтын ажиллагаа 6-аас дээш удаа хийдэг.
- 7.2. Бүртгэл сайн дурын (7.1-д хамаарахгүй) байдлаар нээлттэй байна.

7.3. Бүртгэлийн мэдээллийн хүрээ, хэлбэр, шинэчлэх хугацааг эрх бүхий байгууллага батална.

8 дугаар зүйл. Бүртгэлээс чөлөөлөх

- 8.1. Дараах этгээдийг бүртгэлээс чөлөөлнө:
 - 8.1.1. зөвхөн хувийн сонирхлоор контент хийдэг, арилжааны орлогогүй;
 - 8.1.2. нэг удаагийн, санамсаргүй сурталчилгаа хийсэн;
 - 8.1.3. редакцийн хараат бус мэдээ, нийтлэл, баримтат контент (сурталчилгааны шинжгүй) нийтэлдэг сэтгүүл зүйн байгууллага.

9 дүгээр зүйл. Бүртгэлтэй инфлюзерийн үндсэн үүрэг

- 9.1. Бүртгэлтэй инфлюзер дараах үүрэг хүлээнэ:
 - 9.1.1. арилжааны агуулгыг ил тод тэмдэглэх;
 - 9.1.2. баталгаажуулаагүй эрүүл мэнд, санхүүгийн амлалтаас татгалзах;
 - 9.1.3. хүүхдэд чиглэсэн өндөр эрсдэлтэй сурталчилгааг хориглох;
 - 9.1.4. баримт нотолгоог хадгалах, шаардвал гаргах.

10 дугаар зүйл. Инфлюзерийн эрх

- 10.1. Инфлюзер дараах эрхтэй:
 - 10.1.1. гэрээгээр хамгаалагдсан нөхцөлийг шаардах;
 - 10.1.2. захиалагчийн хууль бус шаардлагыг биелүүлэхээс татгалзах;
 - 10.1.3. нэр төр, зохиогчийн эрх, контентын өмчлөл хамгаалуулах;
 - 10.1.4. шударга бус нэр хүнд унагаах кампанит ажлын талаар гомдол гаргах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АРИЛЖААНЫ АГУУЛГЫН ИЛ ТОД БАЙДАЛ

11 дүгээр зүйл. Арилжааны агуулгыг тэмдэглэх ерөнхий шаардлага

11.1. Арилжааны агуулгыг хэрэглэгч шууд танихуйц байдлаар тод, ойлгомжтой, нууж далдлаагүй тэмдэглэнэ.

11.2. “Сурталчилгаа”, “Ивээн тэтгэлэг”, “Төлбөртэй”, “Affiliate холбоос” гэсэн шошгыг платформын хэрэгслийг ашиглаж эсвэл текст/дуу/дүрсээр давхар илэрхийлж болно.

11.3. Тэмдэглэгээ нь контентын эхэнд, харагдах хэсэгт байрлана.

12 дугаар зүйл. Бэлэг, бартер, хөнгөлөлтийн ил тод байдал

12.1. Бэлэг, бартер, хөнгөлөлт, үйлчилгээ зэрэг өгөөж авсан бол “Бэлэг/бартер” гэж ил тод мэдээлнэ.

12.2. “Үнэгүй авсан” гэх тэмдэглэгээг заавал хэрэглэнэ.

13 дугаар зүйл. Affiliate ба шимтгэлийн ил тод байдал

13.1. Холбоосоор дамжин худалдан авалт хийхэд шимтгэл авч байгаа тохиолдолд тухайн холбоосын ойролцоо “Affiliate” гэдгийг тодорхой тэмдэглэнэ.

13.2. Шимтгэл хэрэглэгчийн үнэд нөлөөлөх эсэхийг ойлгомжтой тайлбарлана.

14 дүгээр зүйл. Далд сурталчилгааг хориглох

14.1. Арилжааны зорилготой контентыг редакцийн/хувийн санал мэтээр далд хэлбэрээр нийтлэхийг хориглоно.

14.2. Платформын автомат тэмдэглэгээг зориудаар зайлсхийх, нуух аргыг хориглоно.

15 дугаар зүйл. Сурталчилгаанд нотолгоо шаардах

15.1. “Эмчилнэ”, “100% баталгаатай”, “хөрөнгө оруулалт 2 дахин өснө” зэрэг шалгах боломжгүй эсхүл нотолгоогүй амлалтыг хориглоно.

15.2. Бүтээгдэхүүний гол нөлөө, эрсдэл, хязгаарлалтыг худал мэдээлэлгүйгээр тайлбарлана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХЭРЭГЛЭГЧИЙН ХАМГААЛАЛТ БА ЭРСДЭЛТ АНГИЛЛУУД

16 дугаар зүйл. Хэрэглэгчийг төөрөгдүүлэхийг хориглох

16.1. Үнэ, чанар, гарал үүсэл, баталгаат хугацаа, буцаалт, хүргэлтийн нөхцөл, даатгал, үйлчилгээний хязгаарлалтыг төөрөгдүүлсэн байдлаар мэдээлэхийг хориглоно.

17 дугаар зүйл. Санхүүгийн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын сурталчилгаа

17.1. Санхүүгийн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалт, крипто хөрөнгө, форекс, дериватив, зээл, даатгалын сурталчилгаанд эрсдэлийн анхааруулга заавал оруулна.

17.2. Зөвшөөрөл/лиценз шаарддаг бүтээгдэхүүнийг зөвшөөрөлгүй этгээд сурталчлахыг хориглоно.

17.3. “Санхүүгийн зөвлөгөө” хэлбэрээр үзүүлсэн бол зөвлөх эрх бүхий эсэхийг тодорхойлно.

18 дугаар зүйл. Эрүүл мэнд, эм, нэмэлт бүтээгдэхүүний сурталчилгаа

18 .1. Эм, эмийн хэрэгсэл, эмчилгээний арга, эрүүл мэндийн үйлчилгээ сурталчлахдаа баталгаат эх сурвалж, зөвшөөрөл, заавар, эсрэг заалтыг дурдана.

18 .2. Эмчилгээний үр дүнг хэтрүүлэн сурталчлах, онош тавих, эмийн хэрэглээг эмчийн зөвлөгөөгүй уриалахыг хориглоно.

19 дүгээр зүйл. Хүүхдэд чиглэсэн сурталчилгааны тусгай хамгаалалт

19.1. Хүүхдэд чиглэсэн контентод мөрийтэй тоглоом, өндөр эрсдэлтэй санхүүгийн бүтээгдэхүүн, насанд хүрэгчдийн бүтээгдэхүүн, хүчирхийлэл өдөөгч зүйл, мөн хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүнийг сурталчлахыг хориглоно.

19.2. Хүүхдийг худалдан авалт хийхийг шууд уриалах, эцэг эхийг шахах агуулга (pester power) ашиглахыг хориглоно.

20 дугаар зүйл. Харанхуй загвар, далд төлбөрийг хориглох

20.1. Хэрэглэгчийг санаатайгаар төөрөгдүүлэх интерфэйс, далд төлбөр, автоматаар сунгах захиалга, цуцлахад хүндрэлтэй нөхцөл зэргийг уриалах, сурталчлахыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

КОНТЕНТЫН ЁС ЗҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

21 дүгээр зүйл. Нийгмийн хор нөлөөтэй контент

21.1. Хүчирхийлэл өдөөгч, үзэн ядалт, ялгаварлан гадуурхалт, хууль бус үйл ажиллагааг сурталчилсан контентыг арилжааны зорилгоор түгээхийг хориглоно.

22 дугаар зүйл. Хуурамч гэрчлэл, хуурамч хэрэглэгчийн сэтгэгдэл

22.1. Хуурамч “review”, хиймэл лайк/дагагч/үзэлт худалдаж авах, хуурамч хэрэглэгчийн сэтгэгдлийг зохион байгуулахыг хориглоно.

23 дугаар зүйл. AI/хиймэл оюун ухаан ашиглаж засварласан контентын ил тод байдал

23.1. Бүтээгдэхүүний үр дүн, хүний дүр төрх, “өмнө-дараа” зургийг бодит мэтээр гуйвуулах хэмжээний AI/засварласан бол “Засварласан/AI ашигласан” гэж тэмдэглэнэ.

23.2. Эрүүл мэнд, гоо сайхны үр дүнг гуйвуулсан засварыг сурталчилгаанд ашиглахыг хязгаарлана.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭ, ХАРИУЦЛАГЫН ХУВААРИЛАЛТ

24 дүгээр зүйл. Инфлюзер захиалагчийн гэрээ

24.1. Арилжааны хамтын ажиллагаа нь бичгээр (цахим хэлбэрийг оролцуулан) гэрээгээр баталгаажина.

24.2. Гэрээнд дор дурдсан заалтыг заавал тусгана:

24.2.1. төлбөр, өгөөжийн төрөл, хугацаа;

24.2.2. ил тод тэмдэглэгээ хийх үүрэг;

24.2.3. хариуцлага, зөрчил гарсан тохиолдлын нөхөн төлбөр;

24.2.4. зохиогчийн эрх, контент ашиглах хүрээ;

24.2.5. мэдээлэл, нотолгоо баталгаажуулах үүрэг.

25 дугаар зүйл. Агентлагийн үүрэг

25.1. Агентлаг инфлюзерийг хууль, стандартын талаар мэдээллээр хангаж, гэрээний ил тод байдлыг баталгаажуулна.

25.2. Агентлаг худал мэдээлэл өгөх, далд сурталчилгааг зохион байгуулахыг хориглоно.

26 дугаар зүйл. Захиалагчийн үүрэг

26.1. Захиалагч бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх бодит баримт, зөвшөөрөл, эрсдэлийн мэдээллийг инфлюзерт бүрэн өгнө.

26.2. Захиалагч инфлюзерийг хууль зөрчихөөр шахахыг хориглоно.

27 дугаар зүйл. Хариуцлагын хамтын зарчим

27.1. Далд сурталчилгаа, худал амлалт, зөвшөөрөлгүй бүтээгдэхүүн сурталчилсан тохиолдолд инфлюзер, агентлаг, захиалагч оролцооны хэмжээгээр хамтран хариуцна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ТАТВАР, БҮРТГЭЛТЭЙ ХОЛБОГДСОН ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТ

28 дугаар зүйл. Орлогын ил тод байдал, тайлагнал

28.1. Бүртгэлтэй инфлюзер орлого, гэрээ, хамтын ажиллагааны мэдээллийг татварын хууль тогтоомжийн дагуу тайлагнана.

28.2. Эрх бүхий байгууллага нь зөвхөн энэ хуулийн хэрэгжилтэд шаардлагатай хүрээнд нэгтгэсэн статистик мэдээлэл шаардаж болно.

29 дүгээр зүйл. Шимтгэл, зуучлалын ил тод байдал

29.1. Агентлагийн шимтгэл, зуучлалын хөлс, хувь тооцох аргачлалыг гэрээнд тодорхой тусгана.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ПЛАТФОРМЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

30 дугаар зүйл. Платформын үүрэг

30.1. Платформ Монгол Улсын хэрэглэгчдэд чиглэсэн арилжааны агуулгын ил тод шошго(paid partnership label) ашиглах нөхцөлийг дэмжинэ.

30.2. Гомдол, мэдээлэл хүлээн авах суваг, контент тайлагнах механизм ажиллуулна.

31 дүгээр зүйл. Платформоос мэдээлэл шаардах

31.1. Эрх бүхий байгууллага нь хуульд нийцсэн үндэслэлээр хувь хүний өгөгдөл хамгааллыг зөрчихгүйгээр статистик болон хэрэг хянан шалгахтай холбоотой мэдээллийг шаардаж болно.

32 дугаар зүйл. Хууль бус арилжааны контентын тухай мэдэгдэл

32.1. Платформ нь илт хууль бус (зөвшөөрөлгүй эм, залилан, насанд хүрэгчдийн хориотой бүтээгдэхүүн) арилжааны контентын талаар эрх бүхий байгууллагын мэдэгдлийг хүлээн авч, шуурхай арга хэмжээ авна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ

33 дугаар зүйл. Хяналт шалгалтын үндсэн хэлбэр

33.1. Эрх бүхий байгууллага эрсдэлд суурилсан байдлаар мониторинг, шалгалт, чиглэл өгч ажиллана.

33.2. Хүүхэд, эрүүл мэнд, санхүүтэй холбоотой ангиллыг өндөр эрсдэлтэйд тооцно.

34 дүгээр зүйл. Гомдол гаргах эрх

34.1. Хэрэглэгч, иргэн, байгууллага инфлюенсерийн арилжааны контенттой холбоотой гомдлыг эрх бүхий байгууллагад гаргана.

34.2. Гомдол шийдвэрлэх хугацаа, журам, нотлох баримтын шаардлагыг эрх бүхий байгууллага батална.

35 дугаар зүйл. Нотлох баримт хадгалах

35.1. Инфлюзер арилжааны хамтын ажиллагааны гэрээ, өгөөжийн нотолгоо, бүтээгдэхүүний зөвшөөрөл/баталгаатай холбоотой баримтыг 2 жилээс доошгүй хугацаанд хадгална.

36 дугаар зүйл. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

36.1. Эрх бүхий байгууллага анхааруулга, зөвлөмж, сургалт, нийтлэг зөрчлийн тайлан, загвар тэмдэглэгээний гарын авлага гаргана.

АРАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

37 дугаар зүйл. Зөрчлийн төрлүүд

37.1. Дараах үйлдэл/эс үйлдэхүйг зөрчилд тооцно:

37.1.1. арилжааны агуулгыг тэмдэглээгүй/далдалсан;

37.1.2. худал, төөрөгдүүлсэн мэдээлэл түгээсэн;

37.1.3. зөвшөөрөлгүй санхүү/эрүүл мэндийн бүтээгдэхүүн сурталчилсан;

37.1.4. хүүхдэд хориотой сурталчилгаа хийсэн;

37.1.5. хуурамч сэтгэгдэл, хуурамч үзэлт/дагагч ашигласан;

37.1.6. баримт хадгалаагүй, шалгалтад саад учруулсан.

38 дугаар зүйл. Анхааруулга ба залруулах

38.1. Анхны, бага эрсдэлтэй зөрчилд эрх бүхий байгууллага анхааруулга өгч, 24-72 цагийн дотор залруулах хугацаа тогтоож болно.

39 дүгээр зүйл. Захиргааны арга хэмжээ

39.1. Дараах арга хэмжээг авч болно:

39.1.1. зөрчил арилгах албан шаардлага;

39.1.2. залруулга, тайлбар нийтлүүлэх;

39.1.3. давтан зөрчилд бүртгэлийг түр түдгэлзүүлэх;

39.1.4. хүүхдэд чиглэсэн контентын сурталчилгааны эрхийг хязгаарлах.

40 дүгээр зүйл. Торгууль, шийтгэл (жишиг загвар)

40.1. Торгуулийн хэмжээг “Зөрчлийн тухай хууль”-тай уялдуулан тогтооно.

40.2. Энэ хуулийн 37.1.1-37.1.6-д заасан зөрчил тус бүрт хувь хүн, хуулийн этгээдэд ногдуулах торгуулийн доод/дээд хэмжээг дагалдах хуулиар тогтооно.

40.3. Давтан, зохион байгуулалттай, өндөр хохиролтой зөрчилд торгуулийн хэмжээг нэмэгдүүлнэ.

41 дүгээр зүйл. Хохирол нөхөн төлүүлэх

41.1. Энэ хуулийг зөрчсөнөөс хэрэглэгчид учирсан шууд хохирлыг Иргэний хуульд нийцүүлэн нөхөн төлүүлнэ.

42 дугаар зүйл. Эрүүгийн шинжтэй үйлдэл

42.1. Залилан, хууль бус сурталчилгаа, хор уршиг ихтэй хуурамч эмчилгээ, санхүүгийн пирамид зэрэг эрүүгийн шинжтэй үйлдэл илэрвэл холбогдох хуулийн байгууллагад шилжүүлнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ИЛ ТОД БАЙДЛЫН СТАНДАРТ, СУРГАЛТ

43 дугаар зүйл. Стандарт, аргачлал

43.1. Эрх бүхий байгууллага арилжааны контент тэмдэглэх стандарт, өндөр эрсдэлтэй ангиллын анхааруулгын загвар, хүүхдэд чиглэсэн контентын шаардлагыг батална.

43.2. Платформын өөрийн шошгололт болон энэ хуулийн шаардлагыг уялдуулах зөвлөмж гаргана.

44 дүгээр зүйл. Чадавхжуулалт, сургалт

44.1. Эрх бүхий байгууллага инфлюенсер, агентлаг, захиалагчид зориулсан сургалт, зөвлөмж, нээлттэй материал бэлтгэнэ.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

ШИЛЖИЛТ, ЭЦСИЙН ЗОХИЦУУЛАЛТ

45 дугаар зүйл. Хуулийг хэрэгжүүлэх журам

45.1. Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 90 хоногийн дотор Засгийн газар хэрэгжилтийг хангах журмуудыг батална.

45.2. Бүртгэлд хамрагдах этгээд 6 сарын дотор бүртгүүлнэ.

45.3. Энэ хуультай холбогдон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар дагалдах хуулийн төслийг боловсруулна.